# ХЭНТИЙ АЙМГИЙН 2022 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРАЛЫН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2022 оны 04 дүгээр сарын 04

Хүснэгт -1

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо | Шийдвэрлэлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэгдсэн | Хугацаа болоогүй | Шийдвэрлэлт / %/ |
| 1 | Аймгийн ЗДТГазар | 80 | 75 | - | - | 5 | 93.7 |
| 2 | Агентлагууд | 379 | 365 | - | - | 14 | 96.3 |
| 3 | Сумд | 562 | 522 | - | - | 40 | 93.0 |
| **Дүн** | | **1021** | **962** | **-** | **-** | **59** | **942** |

Хүснэгт-2

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт | Үүнээс | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | амаар | Бичгээр | 11-11 төвөөр | Цахим хэлбэрээр | Утсаар хандсан | Биечлэн уулзсан | Бусад |
| 1 | Аймгийн ЗДТГазар | 80 | - | 42 | 2 | - | 36 | - | - |
| 2 | Агентлагууд | 379 | - | 354 | - | 4 | 15 | - | 6 |
| 3 | Сумд | 562 | - | 555 | - | - | - | 2 | 5 |
| **Нийт** | | **1021** | **-** | **951** | **2** | **4** | **51** | **2** | **11** |

Хүснэгт 3

| № | Байгууллагын нэр | Зонхилж байгаа асуудал/тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/ |
|---|---|---|
| 1 | Аймгийн Засаг даргын Тамгын газар | Нийт-80 1.Хүсэлт-80 /100%/<br>1.Архины эмчилгээнд хамрагдах хүсэлт 11 /13.7%/<br>2.Мөнгөн тусламж эд материалын дэмжлэг хүссэн 10 /12.5%/<br>3.Газар эзэмшил, өмчлөлтэй холбогдсон 6 /7.5%/<br>4. Барилгын өргөтгөл хийлгүүлэхгүй тухай хүсэлт 5 /6.2%/<br>5. Халаалт, дулаантай холбогдсон асуудлаар 5 /6.2%/ |
| 2 | Агентлагууд | Нийт-379 1.Хүсэлт- 375 /99.0%/<br>2. Гомдол-2 /0.5%/<br>3.Талархал-2 /0.5%/<br>1.Ажилд орох, чөлөөлүүлэх, ажлын байрны шилжилт хөдөлгөөнтэй холбогдсон асуудлаар 62 /16.3%/<br>2.Гамшгаас хамгаалах улсын байцаагчийн дүгнэлт, тодорхойлолт, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах хүсэлт 47 /12.4%/<br>3.Тэтгэвэр тэтгэмж, нөхөн олговортой холбоотой 23 /6.0%/<br>4.Мөнгөн тусламж, эд материалын дэмжлэг хүссэн 6 /1.6%/<br>5. Унд, ахуйн хэрэглээний цооног гаргуулах хүсэлт 2 /0.5%/ |
| 3 | Сумд | Нийт-562 1.Хүсэлт- 559 /99.5%/ |

| | | |
|---|---|---|
| | | 3.Санал- 3 /0.5%/<br>1.Мод бэлтгэх, зөвшөөрөл хүссэн 257 /45.7%/<br>2.Газар, эзэмшил, өмчлөлтэй холбоотой 157 /28.0%/<br>3.Ажил хөдөлмөр, эрхлэлттэй холбогдсон 58 /10.3%/<br>4.Мөнгөн тусламж, эд материалын дэмжлэг хүссэн 34 /6.0%/<br>5.Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговортой хөнгөлттэй холбогдсон 19 /3.4%/ |
| 4 | Хэнтий | Нийт- 1021 1.Хүсэлт- 1014 /99.3%/<br>2.Гомдол- 2 /0.2%/<br>3.Санал- 3 /0.3%/<br>4.Талархал-2 /0.2%/<br>1.Мод бэлтгэх, зөвшөөрөл хүссэн хүсэлт 257 /25.2%/<br>2.Газар эзэмшил, өмчлөлтэй холбогдсон 163 /16.0%/<br>3. Ажил хөдөлмөр, эрхлэлттэй холбогдсон 120 /11.7%/<br>4.Мөнгөн тусламж, эд материалын дэмжлэг хүссэн 50 /4.9%/<br>5.Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн дүгнэлт, тодорхойлолт, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулахыг хүссэн 47 /4.6%/<br>- Мод бэлтгэх хүсэлт гаргасан 257 иргэний мод бэлтгэх эрхийг олгох талаар хүсэлт гаргасныг ойн ангид шилжүүлэн хуулийн дагуу болзол хангасан иргэдэд зөвшөөрөл олгосон байна.<br>-2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу иргэдэд төрөөс үнэгүй олгох газрын өргөдлийг иргэдээс хүлээн авч, өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээ олгосон. Өвөлжөө хаваржааны газраа эзэмших, өмчлөх, кадастрын зураглал хийлгэх тухай хүсэлт гаргасан иргэдийн асуудлыг Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн сумын ИТХуралд уламжилж ИТХ-ын тогтоолоор газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу шийдвэрлэж хариуг хүсэлт гаргасан иргэдэд хүргүүлсэн. Иргэдийн хүсэлтээр эзэмшил, өмчлөлийн газрыг хэмжилт хийж, өвөлжөө хаваржааны газрыг чөлөөлүүлэх, гэрчилгээ олгох, газрын эзэмшлийн эрх шилжүүлэх тухай хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээн авч шийдвэрлэсэн. Мөн эзэмшлийн газраа өмчлөлийн гэрчилгээ авахаар бүрдүүлсэн 87 иргэний материалыг хүлээн авч захирамж гаргуулан олгосон.<br>-Ажил хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон асуудлаар хандсан иргэдийг ажилд томилох, ажилд орох нөөцийн бүртгэлд бүртгэх, ажлаас чөлөөлөгдөх хүсэлийг хүлээн авч шийдвэрлэсэн. Мөн өөр сум болон аймаг руу шилжих хүсэлт гаргасныг хуулийн дагуу хянан шийдвэрлэсэн. Ажлын байраар хангах төсөл хөтөлбөрт хамруулж, шинээр зээл олгож, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд дэмжлэг үзүүлсэн.<br>- Мөнгөн тусламж, эд материалын дэмжлэг хүссэн иргэдийн хүсэлтийг судлан Аймгийн Засаг даргын нөөц сангаас мөнгөн тусламж, сумдын засаг дарга нар орон нутгийн хөгжлийн сангийн зорилтот бүлгийн хөрөнгөөс эмчилгээний зардал, буцалтгүй тэтгэмж олгосон. Сумдад хандаж ирүүлсэн эмчилгээний зээлэнд 24 иргэн хамрагдахаар судлагдан Сумын ИТХ-ын тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн шийдвэрлэж зээлийн гэрээг байгуулж мөнгөн туслаж олгосон.<br>-Онцгой байдлын газарт иргэдээс гамшгаас хамгаалах улсын байцаагчийн дүгнэлт, тодорхойлолт, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулахыг хүссэн өргөдөл ирснийг бүрэн шийдвэрлэж дүгнэлтийг гаргаж өгсөн.<br>• Аймгийн хэмжээнд “Иргэдээ сонсъё-70563111” утас өдөр бүр иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад |

| | | | |
|---|---|---|---|
| | | | танилцуулан харъяалан шийдвэрлэх байгууллагад шилжүүлэн 36 иргэний санал хүсэлтийг шийдвэрлэв. Шийдвэрлэлтийн хугацаанд Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга байнга хяналт тавьж ажилласан.<br>• Сум, агентлаг бүр 7 хоног тутамд иргэдтэй уулзах хуваарь гаргаж, иргэдийн санал бодлыг сонсож, багийн иргэдийн нийтийн хурал хийж тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж, 2022 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт хөтөлбөр, төсөл арга хэмжээнд иргэдээс санал авах ажлын явцыг саналын хуудас, цахимаар хамруулж санал авсан.<br>• Төрийн байгууллагуудад санал хүсэлтийн хайрцаг байршуулж, бүх нийтийн бэлэн байдлын үед иргэдийг заавал биеэр ирүүлэх шаардлага гаргахгүйгээр 70563111, 70562906, 98173788, 70563786, 70562027, 70562267, 77861220, 70562261,70562868 нээлттэй утсыг тогтмол ажиллуулж, төрийн байгууллагын үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтийг шууд хүлээн авч хариулт өгч ажилласан.<br>• Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор “Өргөдөл гомдлын цахим программ”-д бүртэлийг хөтөлж байгаа эсэх, шийдвэрлэлтийн явц, баримт бичгийг хавсаргаж байгаа эсэх, шийдвэрлэлт үр дүнтэй эсэх, байгууллагын даргын цахим бүртгэлд цохолт хийж шилжүүлж байгаа эсэхийг байгууллага бүр дээр очиж 62 байгууллагад хянан шалгах ажил хийгдэж, удирдлагын зүгээс хяналт тавьж ажиллаж байна.<br>• Аймгийн Засаг дарга иргэдтэй уулзах цагаар 55 иргэн биечлэн уулзаж санал хүсэлтээ илэрхийлсэн ба дийлэнх нь дэмжлэг болон түрээсийн орон сууцанд хамруулах хүсэлт байсныг тухай бүрт хариу өгч ажилласан. Мөн Баянхутаг, Галшар, Бор-Өндөр, Дархан, Баянмөнх, Дэлгэрхаан, Мөрөн, Хэрлэн сумын 38 багт хүрч 3500 гаруй иргэдтэй иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж 3500 иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч боломжтойг нь газар дээр нь шийдвэрлэж, шийдвэрлэхэд хүндрэлтэй өргөдлийг Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар оруулж, хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн.<br>• Хэнтий аймгийн ард иргэдийг хямд төсөр үнэтэй орон сууцаар хангах зорилгоор “Хэнтий орон сууц” аж ахуйн тооцоот орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг аймгийн Засаг даргын санаачилгаар байгуулсан. Ингэхдээ орон сууцад орох иргэд, төрийн албан хаагчдын хүсэлт, тэдний амьжиргааны эх үүсвэр дээр хийсэн судалгаанд суурилан боловсруулж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор дээрх үйлдвэрийн газрыг байгуулсан байна. Үйлдвэрийн газар ажилласнаар ажлын байрыг нэмэгдүүлж, аймгийн ард иргэдийг хямд, чанартай орон сууцаар хангах, зах зээлийн үнээс хяид үнээр урьдчилгаа төлбөргүй орон сууцаар хангах, орон нутгийн төсвөөр орон сууц барих зорилгыг дэвшүүлж, орон нутгийн ажилчдаа барилгын салбарт ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлж байна. Эхний ээлжинд талын язгууртан хороололд 3 корпус, 100 шахам айлын орон |

| | | |
|---|---|---|
| | | сууцыг орон нутгийн төсвөөр ашиглалтад оруулахаар ажиллаж байна. |